



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/170-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Аудитор: Утас: 7036-3047	Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn Б.Батмөнх Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn Б.Наранцэцэг Цахим хаяг: Narantsetsegba@audit.gov.mn
Сүхбаатар сум 2025 он		

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-14
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	15-19
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	15
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	16
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	16-17
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17-19
4. Аудитын тайлан	19-21
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20-21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
5. Аудитын илрүүлэлт	22-24
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	25

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын төв



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА Ж.ОД ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.24 № МА-2025/40-МА-СТА-ШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус газар нь аймгийн Засаг даргын 2023 оны А/146 дугаар захирамжаар 62 орон тоотой ажиллахаар батлагдсанаас 30 орон тоо нөхөгдөөгүйгээс 11 ажлын байрыг бусад албан хаагчдаар хавсран гүйцэтгүүлж /цалинтай 5 болон цалингүй 6/ байгаа бөгөөд үүнээс хуулийн эрх зүйн зөвлөгөө хариуцсан мэргэжилтэн, эрүүл мэндийн боловсрол, сургалт, сурталчилгаа хариуцсан албан хаагчийн албан үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж байна.

Аудитын гол асуудал

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газар нь Эрүүл мэндийн сайдын 2010 оны 138 дугаар тушаалаар ЭМЯ болон түүний харьяа байгууллагуудын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа нь тухайн цаг үеэс

хойш нягтлан бодох бүртгэлтэй холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам зэрэг хууль эрх зүйн актуудад орсон өөрчлөлтүүд мөрдөгдөхгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус газраас хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны нэмэгдэлд 222 албан хаагчид нийт 1,646,846.8 мянган төгрөг, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 30 албан хаагчид 766,627.2 мянган төгрөгийг олгосон бөгөөд эдгээр нь нийт зардлын 73.7 хувийг уг зардал эзэлж байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>114,665,905.19</u>	<u>33,420,616.91</u>
33	АВЛАГА	88,224,449.00	6,731,660.72
33300	Татаас, санхүүжилтийн авлага	88,224,449.00	6,731,660.72
35	БАРАА МАТЕРИАЛ	26,441,456.19	26,688,956.19
351	Түүхий эд материал	15,139,287.19	15,139,287.19
35110	Тусгай зориулалттай материал	9,371,787.19	9,371,787.19
35130	Эм боох материал	5,767,500.00	5,767,500.00
354	Хангамжийн материал	11,302,169.00	11,549,669.00
35410	Бичиг хэргийн материал	296,149.00	296,149.00
35420	Аж ахуйн материал	11,006,020.00	11,253,520.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>591,908,719.43</u>	<u>518,175,112.07</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	591,908,719.43	518,175,112.07
392	Биет хөрөнгө	328,591,519.43	254,857,912.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	147,594,083.00	147,594,083.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-38,817,342.93	-46,195,531.17
39203	Авто-тээврийн хэрэгсэл	216,505,880.00	216,505,880.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-193,366,991.24	-213,200,324.60
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	419,344,891.73	430,629,791.73
39206	Хуримтлагдсан элэгдэл	-289,066,453.14	-338,429,791.64
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	162,238,218.62	163,753,518.62
39208	Хуримтлагдсан элэгдэл	-136,167,831.13	-142,087,830.63
39214	Бусад үндсэн хөрөнгө	43,428,700.00	43,428,700.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-7,082,895.48	-11,121,843.24
39217	Ном	3,981,260.00	3,981,260.00
393	Биет бус хөрөнгө	263,317,200.00	263,317,200.00
39301	Программ хангамж	7,479,711.40	00.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-7,479,711.40	00.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>706,574,624.62</u>	<u>551,595,728.98</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>706,574,624.62</u>	<u>551,595,728.98</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	706,574,624.62	551,595,728.98
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	140,566,428.00	140,566,428.00
51101	Өмч: - төрийн	140,566,428.00	140,566,428.00
512	Хуримтлагдсан үр дүн	501,908,131.62	346,929,235.98
51210	Өмнөх үеийн үр дүн	493,192,159.71	501,908,131.62
51220	Тайлант үеийн үр дүн	8,715,971.91	-154,978,895.64
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	64,100,065.00	64,100,065.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>706,574,624.62</u>	<u>551,595,728.98</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/Төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,317,731,596.13	4,407,322,218.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	834,094,959.64	543,278,955.12
120	Нийтлэг татварын бус орлого	834,094,959.64	543,278,955.12
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,670,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,670,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	4,722,258.00	235,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	826,702,701.64	543,043,955.12
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,483,636,636.50	3,864,043,263.08
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,313,356,750.50	3,700,072,186.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,313,356,750.50	3,700,072,186.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	170,279,886.00	163,971,077.08
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	51,022,150.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	80,219,488.00	77,618,064.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	90,060,398.00	35,330,862.58
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,296,911,763.34	4,562,301,113.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,296,911,763.34	4,562,301,113.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,753,024,171.80	1,891,310,758.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	626,224,639.32	863,017,904.40
210101	Үндсэн цалин	393,535,913.74	502,320,351.00
210102	Нэмэгдэл	149,493,119.08	255,967,956.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,135,469.88	43,515,238.00
210104	Урамшуулал	49,060,136.62	61,214,359.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,068,618.48	107,697,728.49
210201	Тэтгэврийн даатгал	53,539,908.61	74,281,629.45
210202	Тэтгэмжийн даатгал	6,964,525.11	8,552,814.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,959,936.99	4,260,937.82
210204	Ажилгүйдлийн даатгал	1,141,577.69	4,034,427.04
210205	Эрүүл мэндийн даатгал	12,462,670.08	16,567,920.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,136,184.71	4,666,685.94
210301	Гэрэл, цахилгаан	246,809.71	1,016,594.94
210302	Түлш, халаалт	8,889,375.00	3,650,091.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,053,289.45	41,940,233.00
210401	Бичиг хэрэг	3,807,600.00	6,551,450.00
210402	Тээвэр, шатахуун	13,336,394.00	30,100,803.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,108,520.45	4,536,430.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,800,775.00	751,550.00
2105	Нормативт зардал	831,961,813.41	549,385,355.12
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	830,318,413.41	543,197,055.12
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,643,400.00	6,188,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,650,810.00	41,096,622.58
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	949,500.00
210604	Урсгал засвар	9,650,810.00	40,147,122.58
2107	Томилолт, зочны зардал	13,525,900.00	26,196,850.00
210702	Дотоод албан томилолт	13,525,900.00	26,196,850.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,623,410.00	14,528,460.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,438,950.00	2,424,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,092,000.00	3,064,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	134,860.00	70,560.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,880,600.00	8,892,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	150,779,506.43	242,780,919.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	68,746,086.00	155,647,112.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	600,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	82,033,420.43	86,533,807.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,543,887,591.54	2,670,990,354.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,371,300,480.00	2,402,150,050.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	750,682,480.00	766,627,152.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	578,693,000.00	1,632,638,798.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	41,925,000.00	2,884,100.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	172,587,111.54	268,840,304.95
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	172,587,111.54	268,840,304.95
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>20,819,832.79</u>	<u>(154,978,895.64)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>20,819,832.79</u>	<u>(154,978,895.64)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			Төгрөгөөр/
код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,486,306,636.50</u>	<u>3,952,267,712.08</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,670,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,670,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,670,000.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,670,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,483,636,636.50	3,952,267,712.08
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,313,356,750.50	3,700,072,186.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,313,356,750.50	3,700,072,186.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	170,279,886.00	252,195,526.08
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	51,022,150.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	80,219,488.00	77,618,064.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	90,060,398.00	123,555,311.58
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	<u>2,480,806,936.50</u>	<u>3,940,252,512.08</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,480,806,936.50	3,940,252,512.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	848,694,895.96	1,262,530,496.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	626,224,639.32	862,943,067.00
210101	Үндсэн цалин	374,879,337.04	502,320,351.00
210102	Нэмэгдэл	166,154,697.08	255,967,956.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,130,468.58	43,515,238.00
210104	Урамшуулал	49,060,136.62	61,139,522.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,068,618.48	107,772,565.89
210201	Тэтгэврийн даатгал	53,539,908.61	74,342,750.85
210202	Тэтгэмжийн даатгал	6,964,525.11	8,552,814.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,959,936.99	4,242,865.93
210204	Ажилгүйдлийн даатгал	1,236,747.71	4,066,214.93
210205	Эрүүл мэндийн даатгал	12,367,500.06	16,567,920.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,744,184.71	4,666,685.94
210301	Гэрэл, цахилгаан	246,809.71	1,016,594.94
210302	Түлш, халаалт	7,497,375.00	3,650,091.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,391,009.45	42,095,753.00
210401	Бичиг хэрэг	4,453,860.00	6,912,250.00
210402	Тээвэр, шатахуун	19,573,664.00	29,030,523.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,102,360.45	5,334,430.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,261,125.00	818,550.00
2105	Нормативт зардал	1,033,400.00	5,589,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	655,000.00	643,100.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	378,400.00	4,946,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,114,110.00	43,108,622.58
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,788,500.00	1,780,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,265,000.00	1,241,500.00
210604	Урсгал засвар	11,060,610.00	40,087,122.58
2107	Томилолт, зочны зардал	13,332,000.00	25,386,850.00
210702	Дотоод албан томилолт	13,332,000.00	25,386,850.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,834,310.00	14,588,460.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,649,850.00	2,484,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,092,000.00	3,064,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	134,860.00	70,560.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,880,600.00	8,892,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68,952,624.00	156,378,592.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	68,403,624.00	155,778,592.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	549,000.00	600,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,632,112,040.54	2,677,722,015.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,371,300,480.00	2,402,150,050.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	750,682,480.00	766,627,152.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	578,693,000.00	1,632,638,798.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	41,925,000.00	2,884,100.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	260,811,560.54	275,571,965.67
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	172,587,111.54	268,840,304.95
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	88,224,449.00	6,731,660.72
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>5,499,700.00</u>	<u>12,015,200.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,499,700.00	12,015,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,499,700.00	12,015,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,499,700.00	12,015,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,499,700.00	12,015,200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-5,499,700.00</u>	<u>-12,015,200.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-5,499,700.00	-12,015,200.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	140,566,428.00	64,100,065.00	481,088,298.83	685,754,791.83
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
6	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	20,819,832.79	20,819,832.79
7	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	140,566,428.00	64,100,065.00	501,908,131.62	706,574,624.62
8	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	140,566,428.00	64,100,065.00	501,908,131.62	706,574,624.62
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
12	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-154,978,895.64	-154,978,895.64
14	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	140,566,428.00	64,100,065.00	346,929,235.98	551,595,728.98

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,273,769,700.00	3,431,231,881.05	842,537,818.95	80.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,273,769,700.00	3,431,231,881.05	842,537,818.95	80.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,122,546,800.00	1,029,081,831.05	93,464,968.95	91.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	904,784,900.00	825,612,772.00	79,172,128.00	91.3
210101	Үндсэн цалин	523,713,000.00	502,320,351.00	21,392,649.00	95.9
210102	Нэмэгдэл	249,906,700.00	218,637,661.00	31,269,039.00	87.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	54,127,700.00	43,515,238.00	10,612,462.00	80.4
210104	Урамшуулал	77,037,500.00	61,139,522.00	15,897,978.00	79.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	112,173,100.00	104,139,837.11	8,033,262.89	92.8
210201	Тэтгэврийн даатгал	73,781,700.00	71,904,048.25	1,877,651.75	97.5
210202	Тэтгэмжийн даатгал	9,597,900.00	8,260,164.99	1,337,735.01	86.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,798,900.00	4,080,077.39	718,822.61	85.0
210204	Ажилгүйдлийн даатгал	4,798,900.00	3,926,124.50	872,775.50	81.8
210205	Эрүүл мэндийн даатгал	19,195,700.00	15,969,421.98	3,226,278.02	83.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,749,900.00	4,666,685.94	1,083,214.06	81.2
210301	Гэрэл, цахилгаан	1,000,000.00	1,016,594.94	-16,594.94	101.7
210302	Түлш, халаалт	4,749,900.00	3,650,091.00	1,099,809.00	76.8
2104	Хангамж, бараа материалын зардал	36,471,100.00	36,388,780.00	82,320.00	99.8
210401	Бичиг хэрэг	4,387,200.00	4,260,650.00	126,550.00	97.1
210402	Тээвэр, шатахуун	26,112,400.00	25,975,150.00	137,250.00	99.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,170,500.00	5,334,430.00	-163,930.00	103.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	43,100.00	-	43,100.00	00.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	757,900.00	818,550.00	-60,650.00	108.0
2105	Нормативт зардал	5,589,900.00	5,589,900.00	00.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	643,100.00	643,100.00	00.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,946,800.00	4,946,800.00	00.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,579,600.00	18,479,340.00	100,260.00	99.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	727,000.00	727,000.00	00.00	100.0
210602	Тавилга	1,515,300.00	1,515,300.00	00.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,241,500.00	1,241,500.00	00.00	100.0
210604	Урсгал засвар	15,095,800.00	14,995,540.00	100,260.00	99.3
2107	Томилолт, зочны зардал	13,944,800.00	11,085,250.00	2,859,550.00	79.5
210702	Дотоод албан томилолт	13,944,800.00	11,085,250.00	2,859,550.00	79.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,942,900.00	12,888,460.00	2,054,440.00	86.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	2,562,600.00	784,100.00	1,778,500.00	30.6

	үйлчилгээний төлбөр хураамж				
210803	Даатгалын үйлчилгээ	3,064,600.00	3,064,600.00	00.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	285,600.00	70,560.00	215,040.00	24.7
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	137,900.00	77,000.00	60,900.00	55.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,892,200.00	8,892,200.00	00.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,310,600.00	10,230,806.00	79,794.00	99.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,631,600.00	9,630,806.00	794.00	99.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	679,000.00	600,000.00	79,000.00	88.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,151,222,900.00	2,402,150,050.00	749,072,850.00	76.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,151,222,900.00	2,402,150,050.00	749,072,850.00	76.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,509,958,900.00	766,627,152.00	743,331,748.00	50.8
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,638,379,900.00	1,632,638,798.00	5,741,102.00	99.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,884,100.00	2,884,100.00	00.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,273,769,700.00	3,700,072,186.00	-573,697,514.00	86.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,269,269,700.00	3,700,072,186.00	-569,197,514.00	86.6
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,269,269,700.00	3,700,072,186.00	-569,197,514.00	86.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,500,000.00	0.00	-4,500,000.00	-100.0
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,500,000.00	0.00	-4,500,000.00	-100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	245,463,865.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	245,463,865.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	245,463,865.36
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	37,330,295.00
210102	Нэмэгдэл	37,330,295.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,632,728.78
210201	Тэтгэврийн даатгал	2,438,702.60
210202	Тэтгэмжийн даатгал	292,649.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	162,788.54
210204	Ажилгүйдлийн даатгал	140,090.43
210205	Эрүүл мэндийн даатгал	598,498.14
2104	Хангамж, бараа материалын зардал	5,706,973.00
210401	Бичиг хэрэг	2,651,600.00
210402	Тээвэр, шатахуун	3,055,373.00
2106	Эд хогшил худалдан авах	36,644,482.58
210601	Багаж, техник хэрэгсэл	11,552,900.00
210604	Урсгал засвар	25,091,582.58
2107	Томилолт, зочны зардал	14,301,600.00
210702	Дотоод албан томилолт	14,301,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,700,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,700,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	146,147,786.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	146,147,786.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,731,660.72
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэг шилжүүлэг	6,731,660.72
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	252,195,526.08
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51,022,150.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	77,618,064.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого	123,555,311.58

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газар нь "Нийгмийн эрүүл мэнд болон эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж хэнийг ч орхигдуулахгүйгээр хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалж, дундаж наслалтыг нэмэгдүүлэхэд оршино." гэсэн эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газар, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт эрүүл мэндийн талаар тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлж, тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулах ажлыг орон нутагт удирдан зохион байгуулах,
- Нэгдсэн эмнэлэг, сум, тосгон, өрхийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартын дагуу эмнэлгүүдийг боловсон хүчин, нэн шаардлагатай байгаа багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, эм урвалж бодисоор хангах ажлыг зохион байгуулах,
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулах, товлотт дархлаажуулалтад хүүхэд бүрийг хамруулан, халдварт болон халдварт бус өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлыг сайжруулах,
- 0-5 насны хүүхэд, жирэмсэн эхчүүдэд үзүүлэх тусламж үйлчилгээ, хяналт чанарыг сайжруулж, өвчлөл эндэгдлийг бууруулах,
- Эрүүл мэндийн арга хэмжээний төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлэхэд төрийн ба төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагууд болон гаднын төсөл хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран ажиллах гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд,
- Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд тус тус нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Тайлант онд тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд ЭМЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газар нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газар нь Эрүүл мэндийн сайдын 2010 оны 138 дугаар тушаалаар ЭМЯ болон түүний харьяа байгууллагуудын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөх "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Уг баримт бичгийг баталсан 2010 оноос хойш нягтлан бодох бүртгэлтэй холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам зэрэг хууль эрх зүйн актуудад орсон өөрчлөлийг тусган нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллах нь зүйтэй юм.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 154,978.9 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	88,224.45	6,731.66	-81,492.79
Бараа материал	26,441.45	26,688.96	247.51
Үндсэн хөрөнгө	591,908.72	518,175.11	-73,733.61
Нийт хөрөнгө	706,574.62	551,595.73	-154,978.89
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	706,574.62	551,595.73	-154,978.89
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	706,574.62	551,595.73	-154,978.89

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл болж 6,731.7 мянган төгрөг болж, 81,492.8 мянган төгрөгөөр буурсан нь нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлэх /ЭМЯ-наас

70,000.0 мянган төгрөг, Монголын сумын эмч мэргэжилтний холбооноос 11,492.8 мянган төгрөгийн санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэл төвлөрсөн/ татаас санхүүжилтийн авлага барагдсанаас,

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 518,175.1 мянган төгрөг болж, 73,733.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны хуримтлагдсан элэгдлээс голлон шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус газар нь 2024 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зардлыг тус бүр улсын төсвөөс 4,361,395.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт 38,825.9 мянган төгрөгөөр бууруулж 4,322,569.7 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- Цалин, хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 35,839.1 мянган төгрөгөөр,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 302.5 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 1,380.1 мянган төгрөгөөр,
- Бараа, үйлчилгээний бусад зардлыг 5,070.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн,
- Хангамж, бараа материалын зардлыг 11,373.1 мянган төгрөгөөр,
- Нормативт зардлыг 19.7 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 1,737.9 мянган төгрөгөөр,
- Албан томилолтын зардлыг 6,522.1 мянган төгрөгөөр,
- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 61,765.5 мянган төгрөгөөр тус тус бууруулсан гэх мэт.

Тайлант оны дундуур батлагдсан төсвийг 48,800.0 мянган төгрөгөөр бууруулан төсвийн зохицуулалт хийж, 4,273,769.7 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Хангамж, бараа материалын зардлыг 14,000.0 мянган төгрөгөөр,
- Нормативт зардлыг 4,575.6 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 8,750.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж,
- Цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 62,800.0 мянган төгрөгөөр,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2,600.0 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 3,750.0 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 6,975.6 мянган төгрөгөөр тус тус бууруулсан гэх мэт.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,269,269.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 4,500.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,700,072.2 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Эрүүл мэндийн тусгай зөвшөөрлийн орлого байгууллагын дансанд төвлөрдөггүй атал үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 4,500.0 мянган төгрөгөөр төлөвлөж, баталснаас уг төлөвлөсөн орлого огт бүрдээгүй байна. /ЭМЯ-нд 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 421 дүгээр албан бичгээр орлогын төлөвлөгөөг цуцлуулах саналыг хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй байна./

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,431,231.9 мянган төгрөг буюу 80.3 хувьтай байгаа нь ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардлыг 749,072.8 мянган төгрөгөөр хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,112,915.2	1,019,451.0	93,464.2	91.6
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	3,151,222.9	2,402,150.1	-749,072.8	76.2
3	Хөтөлбөр, төслийн дотоод урсгал	9,631.6	9,630.81	0.8	99.9
	Нийт	4,273,769.7	3,431,231.9	842,537.8	80.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130020401 тоот дансанд нийт 252,195.5 мянган төгрөгийн дараах орлогуудыг төвлөрүүлэн 245,463.9 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, 6,731.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Аймгийн санхүүгийн дэмжлэгээс албан хаагчдын орон нутгийн нэмэгдэл цалинд 41,969.2 мянган төгрөгийн,
- Аймгийн Засаг даргын 2024 оны А/113 дугаар захирамжийн дагуу сургалтын техник хэрэгслийн зардалд 9,053.0 мянган төгрөгийн,
- Татаас санхүүжилтийн авлагын 88,224.4 мянган төгрөгийн,

- ХӨСҮТ-өөс дархлаажуулалт болон ХПВ-г товллолд нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах сургалтын зардалд 47,848.4 мянган төгрөгийн,
- НҮБ-ын хүн амын сангаас нийгмийн эрүүл мэндийн сургалтын баазын засварт 30,091.6 мянган төгрөгийн,
- ЭМЯ-аас цахим эрүүл мэндийн сургалт зохион байгуулахад зориулан 24,530.0 мянган төгрөгийн,
- Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбооноос мэргэжлийн туслалцаа үзүүлэх зардалд 4,364.3 мянган төгрөгийн,
- Орон нутгийн вакцины тээврийн зардалд 5,239.7 мянган төгрөгийн,
- Цахим төндөрийн баталгааны 875.0 мянган төгрөгийн гэх мэт орлого төвлөрсөн.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн үндсэн хөрөнгийн данстай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газар нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 65 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБООУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,296,911.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 32,969.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор тус байгууллагын зүгээс дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Сумдад ажиллах албан томилолтын зардлын батлагдсан төсвийг 2,859.5 мянган төгрөгөөр хэмнэсэн,
- Тус байгууллагын үйл ажиллагаанд ашиглагддаг 1 автомашинд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар ашиглаж байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан *“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”*-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газар нь мэдээлбэл зохих 28 төрлийн 171 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар *“Санхүүгийн тайланд аудит хийх тухай”* албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын тайланг стандартын дагуу үдүүлж, албан хаагчдын гарын үсгээр баталгаажуулаагүй баримтыг нөхөн зуруулж, зураг, гүйцэтгэлийн тайланг хавсаргах зэрэг анхан шатны бүрдэл дутуу баримтуудыг нөхөн бүрдүүлсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3,078.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 335.7 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгөгдсөнөөс биелэлтийг аудитаар дахин хянахад 83.3 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	3,078.4	2	3,078.4	100.0
Зөвлөмж	3	335.7	2	335.7	66.7
Нийт дүн	5	3,414.1	4	3,414.1	83.3

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр буюу ЭМЯ-наас үнэ төлбөргүй шилжиж ирсэн вакцин, эм, эмнэлгийн хэрэгслийг тухай бүр бус бөөн дүнгээр орлого авч, зарлага гаргасан зөрчлийг тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 дэх "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.10: "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Тус газрын төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

- ЭМЯ-ны 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 2/2782 дугаар албан бичгээр ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 60.0 хүртэл хувиар тооцон үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "Өөрчлөлтгүй" дүгнүүлсэн гэх үндэслэлээр газрын дарга, Ж.Од, нягтлан бодогч Д.Нямаа нарт 3,551.0 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

2. Дараагийн аудитаар дараах асуудалд анхаарал хандуулж, авч үзэх шаардлагатай юм. Үүнд:

- Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор хууль бусаар ажлаас халагдсан нь тогтоогдсон /Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн Б/35 дугаар захирамжаар ажлаас чөлөөлөгдсөн/ тус газрын дарга Ж.Одын 2023 оны 12, 2024 оны 1-3 дугаар сард ажилгүй байсан хугацааны цалин хөлс, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд нийт 12,951.5 мянган төгрөгийг байгууллагаас барагдуулсан байна. Иймд дээрх хохирлыг нөхөн төлүүлж, байгууллагыг хохиролгүй болгох арга хэмжээ авч ажилласан эсэхийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй юм.

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой нийт **1,844.5** мянган төгрөгийн дараах алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- 5 нэр төрлийн үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцож, бодуулаагүйгээс санхүүгийн үр дүнг 1,844.5 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна.

Аудитаар нийт **15,216.3** мянган төгрөгийн зөрчил² илэрснээс **4,500.2** мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **10,716.1** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. Тус байгууллагын 17 албан хаагчийг ажлын бус цагаар тайлан, мэдээ, хүлээн авсан гэх үндэслэлээр илүү цагийн нэмэгдлийг тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрүүлэн 1 дүгээр сард **3,842.9** мянган төгрөг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”*, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан *“Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”*-ын 3 дугаар зүйлийн 3 дахь *“Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна”* гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож, олгосон илүү цагийн хөлсийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.2. Төрийн захиргааны 3 албан хаагчид ур чадварын нэмэгдлийг тус бүр 15-25 хувиар тооцож, **657.3** мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан *“Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”*-ын 1-д *“Төрийн үйлчилгээний албан хаагчийн ажил гүйцэтгэх чадвар, ажлын арга барил, идэвх санаачилгыг нь дэмжиж, үр бүтээлтэй ажиллуулах зорилгоор ур чадварын нэмэгдэл олгоход энэ журмыг мөрдөнө.”* гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үндэслэлгүй олгосон ур чадварын нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Албан шаардлага

5.2.1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр буюу ЭМЯ-наас үнэ төлбөргүй шилжиж ирсэн вакцин, эм, эмнэлгийн хэрэгслийг тухай бүр бус бөөн дүнгээр орлого авч, зарлага гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.4 дэх “... удирдлага, нягтлан бодогч нь ... үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

5.2.2. Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/146 дугаар тушаалаар баталсан бүтэц, орон тоог хэтрүүлсэн буюу төсвийн төлөвлөгөөгөөр батлагдаагүй гэрээт ажилтан ажиллуулж, цалин урамшууллын зардалд нийт **10,716.1** мянган төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:

- 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн Б/26 дугаар тушаалаар Б.Чинбаатарыг жолоочийн албан тушаалд томилж, /2024 оны 4, 11, 12 сард/ 1,767.3 мянган төгрөг,
- 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн Б/37 дугаар тушаалаар Б.Эрдэнэчимэгийг гэрээт ажилтнаар томилж, /2024 оны 5-12 сард/ 7,720.3 мянган төгрөгийг,
- 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн Б/50 дугаар тушаалаар нярав Д.Ононгоор үйлчлэгчийн ажил үүргийг хавсран гүйцэтгүүлж, хавсран ажилласны нэмэгдэлд /2024 оны 7-12 сард/ 1,228.5 мянган төгрөгийг гэх мэт.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Баталсан орон тоог мөрдөн, төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, цаашид ашиглагдах боломжгүй хөрөнгийг акталж, данснаас хасуулах саналыг холбогдох газарт хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна. Тухайлбал:

- 2015 онд ЭМЯ-наас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан үлдэх өртөггүй, ашиглагдахгүй 33 ширхэг компьютер,
- Тус байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй УАЗ фургон, Ланд крузер G-78 маркын 2 авто машин /ОБЕГ болон мянганы сорилтын санд бүртгэлтэй/ гэх мэт.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн бүртгэлд дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллагуудад санал хүргүүлэн шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5³ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоогүй	1	1,844.5	1	1,844.5			1	1,844.5				
Дүн	1	1,844.5	1	1,844.5			1	1,844.5				

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байууллагад шилжүүлсэн асуудал	
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		Тоо
Илүү цагийн нэмэгдэл хөлсийг илүү тооцож, олгосон.	1	3,842.9	1	3,842.9								
Төрийн захиргааны албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгосон.	1	657.3	1	657.3								
Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан	1				1							
Батлагдсан орон тоог хэтрүүлсэн, төсвийг зориулалт бусаар зарцуулсан.	1	10,716.1			1	10,716.1						
Хөрөнгийг хууль, эрхийн актад нийцүүлэн бүртгээгүй	1							1				
Дүн	5	15,216.3	2	4,500.2	2	10,716.1	2	10,716.1	1			

/мянган төгрөгөөр/